

**ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ**

/Шинэчилсэн найруулга/

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь гадаадын иргэний эрх зүйн байдлыг тогтоож, гадаадын иргэн Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суухтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж**

2.1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд**

3.1.Энэ хуулийн заалт нь Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөгч, тус улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн /цаашид "гадаадын иргэн" гэх/, гадаадын иргэнийг уригчид хамаарна.

3.2.Хуульд өөрөөр заагаагүй бол гадаадын иргэнд хамаарах энэ хуулийн зохицуулалт нь харьяалалгүй хүнд нэгэн адил үйлчилнэ.

**4 дүгээр зүйл.Дипломат төлөөлөгчийн болон консулын газрын ажилтны дипломат эрх ямба, дархан эрх**

4.1.Энэ хуулийн заалт нь гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага /цаашид "НҮБ" гэх/, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газрын ажилтны дипломат эрх ямба, дархан эрхийг хөндөхгүй.

**5 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1."гадаадын иргэн" гэж Монгол Улсын иргэний харьяалалгүй бөгөөд гадаад улсын иргэний харьяалалтай хүнийг;

5.1.2."уригч" гэж гадаадын иргэнийг Монгол Улсад оршин суухад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн баталгааг гаргаж түүнийг урьсан Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон тус улсад хууль ёсоор 90 хоногоос дээш хугацаагаар оршин суугаа гадаадын иргэнийг;

5.1.3."дамжин өнгөрөгч" гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин нэг улсаас нөгөө улсад зорчиж байгаа гадаадын иргэнийг;

5.1.4."түр ирэгч" гэж Монгол Улсад 90 хүртэл хоногийн хугацаагаар ирсэн гадаадын иргэнийг;

5.1.5."хувийн хэргээр оршин суугч" гэж суралцах, хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулах, гэр бүлийн шалтгаан болон хувийн бусад ажлаар оршин суухаар ирсэн гадаадын иргэн, түүний хамаарал бүхий этгээдийг;

[/Энэ заалт ад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

5.1.6."албан хэргээр оршин суугч" гэж төрийн байгууллагын урилгаар болон Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Засгийн газар хоорондын эрх бүхий байгууллага, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, түүнчлэн гадаад улсын болон олон улсын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллахаар ирсэн гадаадын иргэн, түүний хамаарал бүхий этгээдийг;

[/Энэ заалт ад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

5.1.7."харьяалалгүй хүн" гэж аль ч улсын харьяат бус хүнийг;

5.1.8."цагаач" гэж Монгол Улсын эрх бүхий байгууллагаас цагаачлан оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;

5.1.9."паспорт" гэж олон улсын эрх бүхий байгууллага, түүнчлэн гадаад улсын болон Монгол Улсын Засгийн газраас олгосон буюу хүлээн зөвшөөрсөн олон улсад зорчих баримт бичгийг;

5.1.10."паспортыг орлох баримт бичиг" гэж Монгол Улсын хууль, олон улсын гэрээгээр паспорттай адилтган үзэхээр хүлээн зөвшөөрсөн, тухайн хүнийг гадаад улсын иргэн болохыг гэрчилж байгаа баримт бичгийг;

5.1.11.“Монгол Улсын виз” гэж эрх бүхий байгууллагаас олгосон Монгол Улсын хилээр нэвтрэх, Монгол Улсад тодорхой хугацаанд байх зөвшөөрлийг;

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

5.1.12.“визийн зөвшөөрөл” гэж гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт гадаадын иргэнд виз олгохыг зөвшөөрч олгосон баримт бичгийг;

[/Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтад 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ заалтад 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

5.1.13.“лесе пасе” гэж НҮБ-ын Эрх, Дархын тухай Конвенцийн 7 дугаар зүйлд заасны дагуу НҮБ-ын ажилтан, албан тушаалтанд тус байгууллагаас олгосон олон улсад зорчих баримт бичгийг.

5.1.14.“хамаарал бүхий этгээд” гэж гадаадын иргэний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, хүүхдийг;

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.1.15.“цахим виз” гэж гадаадын иргэнд цахим хэлбэрээр Монгол Улсын виз олгосныг нотлох цахим болон хэвлэмэл баримтыг.

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ**

### **6 дугаар зүйл.Гадаадын иргэний эрх, үүргийн үндсэн зарчим**

6.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг тухайн иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчмыг баримтлан Монгол Улсын хуулиар тодорхойлно.

### **7 дугаар зүйл.Гадаадын иргэний эрх, үүргийн онцлог**

7.1.Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалах зорилгоор хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд гадаадын иргэний эрх, эрх чөлөөнд хуулиар хязгаарлалт тогтоож болно.

7.2.Гадаадын иргэн энэ хуулийн 7.1-д заасны дагуу хуулиар хязгаарласнаас бусад тохиолдолд Монгол Улсын иргэний нэгэн адил эрх, эрх чөлөөг эдэлж, үүрэг хүлээнэ.

7.3.Гадаадын иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт дараахь эрхийг эдэлнэ:

7.3.1.энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсад нэвтрэх, оршин суух;

7.3.2.улсын онц чухал объектод Засгийн газрын зөвшөөрснөөр ажиллах;

7.3.3.улс төрийн орогнол хүсэх;

7.3.4.хууль тогтоомжид заасан бусад эрх.

7.4.Гадаадын иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт дараахь үүрэг хүлээнэ:

7.4.1.Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг сахин биелүүлж, Монголын ард түмний уламжлал, зан заншлыг хүндэтгэх;

7.4.2.энэ хуулийн 24, 26 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлэх;

7.4.3.Монгол Улсын хууль тогтоомжид заасан татвар төлөх;

7.4.4.Монгол Улсад зөвхөн эрх бүхий байгууллагаас олгосон Монгол Улсын виз, оршин суух зөвшөөрлийн хугацаанд байх, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хугацаандаа буюу эрх бүхий байгууллагын шаардсанаар тус улсаас гарах;

7.4.5.паспорт, эсхүл Монгол Улсын эрх бүхий байгууллагаас олгосон оршин суух үнэмлэхийг биедээ авч явах;

[/Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

7.4.6.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

7.5.Гадаадын иргэн Монгол Улсын зэвсэгт хүчин, бусад цэрэгт алба хаах үүрэг хүлээхгүй.

### **8 дугаар зүйл.Гадаадын иргэнд хориглох зүйл**

8.1.Гадаадын иргэнд Монгол Улсын нутаг дэвсгэрт дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

8.1.1.Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ Монгол Улсын эрх ашиг, тус улсын иргэний болон бусад хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд харш үйлдэл хийх;

8.1.2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын болон орон нутгийн хурлын сонгуульд сонгох, сонгогдох, ард нийтийн санал асуулгад оролцох;

8.1.3.Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн үйл ажиллагаа явуулах байгууллага байгуулах, түүнд элсэн орох, хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр улс төрийн аливаа үйл ажиллагаа явуулах;

8.1.4.Монгол Улсын үндэсний эв нэгдлийг бусниулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах, харгис, хүмүүнлэг бус шашны сургаал, номлолыг дэлгэрүүлэх, шашны үйл ажиллагааг хүний эрхийг зөрчсөн, хуульд нийцээгүй бусад аргаар явуулах, садар самуун, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг түгээх, сурталчлах, хэрэглэх;

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

8.1.5.хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр зөвшөөрөлтэй эрхлэхээр заасан үйл ажиллагааг зөвшөөрөлгүй явуулах;

8.1.6.Монгол Улсын виз, оршин суух, бүртгүүлэх журам зөрчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхлэх, шилжин суурьших;

8.1.7.хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагаа.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ БҮРЭН ЭРХ, АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭНИЙ ҮҮРЭГ

#### 9 дүгээр зүйл.Төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх

9.1.Монгол Улсад эрхэмлэн дээдэлдэг үзэл санааны төлөө хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэнд Монгол Улсын Ерөнхийлөгч тус улсад орогнох эрх олгоно.

9.2.Монгол Улсын Засгийн газар гадаадын иргэний асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.2.1.Монгол Улсын визийн ангилал болон визийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, Монгол Улсын виз олгох журам батлах;

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ заалтад 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

9.2.2.гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журмыг батлах;

9.2.3.гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журмыг батлах.

[/Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

9.2.4.тухайлсан улсын иргэнийг Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлөх асуудлыг гадаад харилцааны болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн шийдвэрлэх;

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

9.2.5.хуульд заасан бусад бүрэн эрх

[/Энэ заалтын дугаарт 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

9.3.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гадаадын иргэний асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.3.1.гадаадын иргэн Монгол Улсад оршин суух, харьяалалгүй хүн зорчих үнэмлэхийн загвар, тэдгээрийг эзэмших, хадгалах, ашиглах журмыг батлах;

9.3.2.гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн ёс зүйн болон сахилгын дүрмийг батлах;

9.3.3.гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээлэл харилцан солилцох журмыг батлах;

9.3.4.энэ хуулийн 36.5-д заасан барьцаа гаргах, буцаан олгох, барьцааны хэмжээ тогтоох журмыг батлах;

9.3.5.энэ хуулийн 40.1.5-д заасан олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам батлах;

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

9.3.6.хуульд заасан бусад бүрэн эрх.

[/Энэ заалтын дугаарт 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

9.4.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гадаадын иргэний асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.4.1.хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцсөнөөр Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт визийн асуудал хариуцсан ажилтныг томилж, чөлөөлөх асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах;

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

9.4.2.энэ хуулийн 13.3-т заасан журамд нийцүүлэн хилийн чанадад ажиллах виз мэдүүлгийн төвийн байршлыг тогтоох, сонгон шалгаруулах, гэрээ байгуулах;

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

9.4.3.хуульд заасан бусад бүрэн эрх

[/Энэ заалтын дугаарт 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

9.5.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

9.5.1.гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлтийг зохион байгуулах;

9.5.2.Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнтэй ярилцлага хийх журмыг батлах;

9.5.3.гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх журмыг батлах;

9.5.4.гадаадын иргэнд Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгох журмыг батлах;

9.5.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

9.6.Аймаг, дүүргийн Засаг дарга харьяалах сум, хороонд нь оршин суугаа гадаадын иргэний хаягийн бүртгэлийн мэдээг нэгтгэн хагас жил тутам гаргаж гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад өгөх үүрэгтэй.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

9.7.Сум, хорооны Засаг дарга гадаадын иргэний асуудлаар дараахь эрх, үүрэгтэй.

9.7.1.нутаг дэвсгэртээ оршин суугаа гадаадын иргэний хаягийн бүртгэл хөтлөх;

9.7.2.гадаадын иргэний оршин суугаа газрын талаар тодорхойлолт гаргах;

9.7.3.гадаадын иргэн гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран ажиллах;

9.7.4.хуульд заасан бусад эрх, үүрэг.

## **10 дугаар зүйл.Гадаадын иргэнийг уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг**

10.1.Гадаадын иргэнийг Монгол Улсад урьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

[/Энэ хэсэгт 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

10.1.1.гадаадын иргэнийг хууль тогтоомжид заасны дагуу холбогдох байгууллагад бүртгүүлэх;

10.1.2.гадаадын иргэн Монгол Улсад оршин суухад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаа гаргах;

10.1.3.Монгол улсын виз, оршин суух зөвшөөрлийнх нь хугацаанд гадаадын иргэнийг буцаах.

10.2.Энэ хуулийн 10.1.2-т заасан баталгааны төрөл, хэлбэр, тэдгээрийг мэдүүлэхтэй холбогдсон харилцааг энэ хуулийн 9.2.2-т заасан журмаар зохицуулна.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ВИЗ**

### **11 дүгээр зүйл.Монгол Улсын виз**

11.1.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсад нэвтрэх гадаадын иргэн Монгол Улсын виз (цаашид "виз" гэх)-ийг зохих журмын дагуу авсан байна.

11.2.Визийг хүчин төгөлдөр паспорт буюу паспортыг орлох баримт бичигтэй гадаадын иргэнд олгоно.

11.3.Виз нь хэвлэмэл болон цахим хэлбэртэй байж болно.

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

11.4.Виз нь дипломат, албан, энгийн гэсэн зэрэгтэй байна.

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

11.5.Виз нь орох, дамжин өнгөрөх зориулалттай, Монгол Улсын хилээр нэвтрэх зорилгыг агуулсан ангилалтай, нэг, хоёр, олон удаагийн гэсэн төрөлтэй байна.

[/Энэ хэсэг т 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

11.6.Гадаадын иргэн виз авсан нь түүнийг Монгол Улсад нэвтрүүлэх баталгаа болохгүй.

11.7.Визийн загварыг гадаад харилцааны болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

11.8.Гадаадын иргэнд энэ хуулийн 5.1.12-т заасан визийн зөвшөөрөлгүйгээр “жуулчин” ангиллын, нэг удаагийн, 30 хүртэлх хоногийн хугацаатай, орох визийг олон улсын хилийн боомт дээр олгож болно. Олон улсын хилийн боомт дээр визийн зөвшөөрөлгүйгээр “жуулчин” ангиллын виз олгож болох улсын жагсаалт, виз олгох журмыг энэ хуулийн 9.2.1-д заасан журмаар зохицуулна.

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

## **12 дугаар зүйл.Цахим виз**

[/Энэ зүйлийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

12.1.Цахим виз нь Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын 9 дүгээр хавсралтын холбогдох стандартад нийцсэн байна.

12.2.Цахим виз олгохтой холбогдох харилцааг энэ хуулийн 9.2.1-д заасан журмаар зохицуулна.

## **13 дугаар зүйл.Визийн төв**

[/Энэ зүйлийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

13.1.Визийн төв нь визийн мэдүүлэг хүлээн авах, хүлээн авсан визийн мэдүүлгийг виз олгох байгууллагад үнэн зөв, шуурхай дамжуулна.

13.2.Монгол Улсын визийн төвийн үйл ажиллагааг олон улс, эсхүл тухайн улсдаа энэ төрлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.

13.3.Визийн төвийн байршлыг тогтоох, сонгон шалгаруулах, гэрээ байгуулан ажиллах журмыг Засгийн газар батална.

## **14 дүгээр зүйл.Энгийн зэргийн виз**

14.1.Энэ хуулийн 12, 13 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд гадаадын иргэнд энгийн зэргийн виз олгоно.

14.2.Энгийн зэргийн визийг визийн хуудсан дээр "E" гэсэн латин үсгээр ялгаж тэмдэглэнэ.

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

[/Энэ зүйлийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

## **15 дугаар зүйл.Визийн ангилал**

[/Энэ зүйлийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

15.1.Тухайн гадаадын иргэний хилээр нэвтрэх зорилгыг үндэслэн тодорхой ангиллын виз олгоно. Аялал жуулчлалыг дэмжих зорилго бүхий өдрийн визийг хил дээр олгож болох бөгөөд тухайн виз нь зөвхөн хил орчмын жуулчинд хамаарна.

15.2.Визийн ангиллыг энэ хуулийн 9.2.1-д заасан журмаар тогтооно.

## **16 дугаар зүйл.Виз олгох байгууллага**

16.1.Визийг дараахь байгууллага олгоно:

16.1.1. гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

16.1.2. гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

[/Энэ заал тад 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

16.1.3. Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар.

[/Энэ заал т-ыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

16.2. Виз олгох байгууллага нь Монгол Улсын хууль тогтоомж болон виз олгох журмын дагуу зохих ангиллын визийг олгох, олгохоос татгалзах, ангиллыг өөрчлөх, хугацааг сунгах, хүчингүй болгох бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

16.3. Тухайн ангиллын виз олгоход шаардагдах баримт бичгийн иж бүрдлийг биедээ авч яваа тохиолдолд энэ хуулийн 16.1.1, 16.1.2-т заасан байгууллагаас олгосон визийн зөвшөөрлийн дагуу Монгол Улсын хилийн боомт дээр гадаадын иргэнд зохих ангиллын нэг удаагийн орох, дамжин өнгөрөх визийг олгож болно.

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

## **17 дугаар зүйл. Виз олгох байгууллагын бүрэн эрх**

17.1. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага виз олгох талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1. энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан ангиллын визийг олгох, олгохоос татгалзах, ангиллыг өөрчлөх, хугацааг сунгах, хүчингүй болгох.

17.2. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага виз олгох талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

[/Энэ хэсэг т 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэг т 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

17.2.1. Монгол Улсад түр-ирсэн болон хувийн хэргээр оршин сууж байгаа гадаадын иргэнд энэ хуулийн 15.1.3-15.1.11-д заасан ангиллын олон удаагийн, гарах орох визийг олгох, олгохоос татгалзах, ангиллыг өөрчлөх, хугацааг сунгах, хүчингүй болгох;

17.2.2. тухайн ангиллын виз олгоход шаардагдах баримт бичгийн иж бүрдлийг биедээ авч яваа нөхцөлд Монгол Улсын хилийн боомт дээр гадаадын иргэнд энэ хуулийн 15.1.3-15.1.11-д заасан ангиллын орох, дамжин өнгөрөх виз олгох;

17.2.3. гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон визийн зөвшөөрлийн дагуу хилийн боомт дээр энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан ангиллын визийг гадаадын иргэнд олгох.

17.3. Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар, Монгол Улсын өргөмжит консул нь виз олгох талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.3.1. гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон визийн зөвшөөрлийн дагуу энэ хуулийн 15.1.4, 15.1.5, 15.1.7-д заасан ангиллын 30 хүртэлх хоногийн виз болон мөн хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан ангиллын визийг олгох;

17.3.2. гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон визийн зөвшөөрлийн дагуу энэ хуулийн 17.3.1-д зааснаас бусад визийг олгох.

[/Энэ заал т ад 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ заал т ад 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ зүйлийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

18.1.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол нэг болон хоёр удаагийн орох виз нь гадаадын иргэн Монгол Улсын хилээр нэвтрэх хүртэл 150 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

18.2.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол түр ирэгчид олгох олон удаагийн визийн хүчинтэй байх хугацаа нь 183 буюу 365 хоног байх бөгөөд түр ирэгчийн Монгол Улсад байх хугацаа нь 30 хоног байна.

18.3.Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэнд олгох олон удаагийн визийн хүчинтэй байх хугацаа нь оршин суух зөвшөөрлийн хугацаагаар тодорхойлогдоно.

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

18.4.Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэнд олгосон гарах-орөх визийн хүчинтэй байх хугацаа нь Монгол Улсаас гарснаас хойш 180 хүртэл хоног хүчинтэй байна.

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

18.5.Визийн хуудсан дээр түүний хүчинтэй байх хугацааг нь он, сар, өдөр гэсэн дарааллаар зааж тэмдэглэнэ.

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

## **19 дүгээр зүйл.Монгол Улсад байх хугацааг визээр тодорхойлох**

19.1.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадын иргэн Монгол Улсын хилээр нэвтэрснээс хойш тус улсад байх хугацааг дор дурдсанаар тодорхойлж визэнд заана:

19.1.1.түр ирэгч 90 хүртэл хоног;

19.1.2.дамжин өнгөрөгч 10 хүртэл хоног;

19.1.3.Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэнд хугацаагүйгээр буюу оршин суух зөвшөөрөл олгох хүртэл.

19.2.Энэ хуулийн 19.1.1-д заасан хугацааг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

## **20 дугаар зүйл.Виз, визийн зөвшөөрөл**

20.1.Виз, визийн зөвшөөрлийг уригчийн хүсэлт, энэ хуулийн 10.1.2-т заасан баталгааг харгалзан олгоно.

20.2.Уригч нь гадаадын иргэнд дипломат, албан зэргийн виз олгуулах хүсэлтийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, энгийн зэргийн виз олгуулах хүсэлтийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тус тус гаргана.

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

20.3.Энэ хуулийн 16.1-д заасан виз олгох байгууллага нь Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух хүсэлт гаргасан гадаадын иргэнд виз олгох эсэхийг шийдвэрлэхдээ эрүүл мэндийн шинжилгээ хийлгэхийг шаардаж болно.

20.4.Гадаадын иргэнд виз, визийн зөвшөөрөл олгох, визийн хугацааг сунгахаас татгалзсан үндэслэлийн талаар энэ хуулийн 16.1-д заасан байгууллага тайлбар өгөх үүрэг хүлээхгүй.

## **ТАВДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСАД ОРОХ, ДАМЖИН ӨНГӨРӨХ**

### **21 дүгээр зүйл.Монгол Улсад орох**

21.1.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол хүчин төгөлдөр паспорт буюу паспортыг орлох баримт бичигтэй бөгөөд виз авсан гадаадын иргэн хууль тогтоомжид заасан журмын дагуу Монгол Улсад орж болно.

### **22 дугаар зүйл.Монгол Улсад орохыг үл зөвшөөрөх**

22.1.Дараахь үндэслэл байвал гадаадын иргэнийг Монгол Улсад орохыг үл зөвшөөрнө:

- 22.1.1. 16 насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй гадаадын иргэн хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй бол;
- 22.1.2. нийтийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчнөөр өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй шинж тэмдэг илэрсэн этгээд байвал;

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

- 22.1.3. Монгол Улс тааламжгүй этгээд гэж зарласан бол;
- 22.1.4. олон улсын хэмжээнд эрэн сурвалжилж байгаа бол;
- 22.1.5. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахад харшилж байвал;
- 22.1.6. Монгол Улсад байх, буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй бол;
- 22.1.7. энэ хуульд заасан журмын дагуу албадан гаргасан бөгөөд Монгол Улсад орохыг хориглосон хугацаа дуусаагүй бол.

22.2. энэ хуулийн 22.1.2-т заасан өвчний жагсаалтыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

22.3. Монгол Улсад зорчих, эсхүл нэвтрэх зорилгоо тодорхойлж чадаагүй, зорчих зорилгодоо нийцээгүй ангиллын визтэй бол Монгол Улсад оруулахгүй байж болно.

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

### **23 дугаар зүйл. Монгол Улсаар дамжин өнгөрөх**

23.1. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол хүчин төгөлдөр паспорт буюу паспортын орлох баримт бичигтэй гадаадын иргэн зохих визтэйгээр Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч болно.

23.2. Гадаадын иргэн олон улсын нислэгээр Монгол Улсын нутаг дэвсгэрээр визгүйгээр дамжин өнгөрч болно.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ГАДААДЫН ИРГЭН МОНГОЛ УЛСАД ОРШИН СУУХ**

### **24 дүгээр зүйл. Гадаадын иргэнийг бүртгэх**

[/Энэ зүйлийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

24.1. Гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрэх үед Монгол Улсын хилийн тухай хуулийн 17.6-д заасны дагуу хил хамгаалах байгууллага нь биеийн давхцахгүй өгөгдлийг авч, улсын хилээр нэвтэрсэн зорчигчийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

24.2. Энэ хуулийн 9.2.2-т заасан журамд энэ хуулийн 24.1-д заасан мэдээллийн санд биеийн давхцахгүй өгөгдлийг бүртгүүлэхээс чөлөөлөгдөх үндэслэлийг тусгана.

24.3. Албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэнд түүнийг харьяалах улсын товчлол, төрсөн он, сар, өдөр, хүйс зэрэг өгөгдлийг багтаасан хоорондоо давхцахгүй бүртгэлийн дугаарыг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно.

24.4. Гадаадын иргэнийг орон байраар хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага түүнийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 48 цагийн дотор бүртгүүлэх бөгөөд бүртгэлийг цахимаар хийж болно.

24.5. Энэ хуулийн 24.3, 24.4-т заасан зохицуулалтыг энэ хуулийн 9.2.2-т заасан журмаар зохицуулна.

24.6. Гадаадын иргэнд төрийн үйлчилгээ үзүүлэхдээ энэ хуулийн 24.3-т заасан бүртгэлийн дугаарыг ашиглана.

### **25 дугаар зүйл. Гадаадын иргэний гэр бүлийн байдлын бүртгэл**

25.1. Гадаадын иргэнтэй холбоотой иргэний улсын бүртгэлийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөтөлж, холбогдох мэдээллийг сар бүр гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хууль, 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

### **26 дугаар зүйл. Гадаадын иргэний хаягийн бүртгэл**

26.1. Монгол Улсад хувийн хэргээр болон энэ хуулийн 32.2-т заасан оршин суугч гадаадын иргэн 14 хоногийн дотор сумын Засаг



даргын Тамгын газарт, эсхүл хорооны Засаг даргад хаягийн бүртгэл хийлгэнэ.

26.2.Энэ хуулийн 26.1-д заасан гадаадын иргэн оршин суугаа хаягаа өөрчилбөл анх бүртгүүлсэн газартаа мэдэгдэн хасалт хийлгэж, шилжин очсон сумын Засаг даргын Тамгын газарт, эсхүл хорооны Засаг даргад 14 хоногийн дотор хаягийн бүртгэл хийлгэнэ.

## **27 дугаар зүйл.Монгол Улсад хувийн хэргээр оршин суух**

27.1.Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг гадаадын иргэний хүсэлт, холбогдох байгууллагын санал, зөвшөөрлийг харгалзан гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 5 хүртэл жилээр олгож, тухай бүр 3 хүртэл жилийн хугацаагаар сунгаж болно.

[/Энэ хэсэг т 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан/](#)

27.2.Гадаадын иргэнд Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг дараахь хэлбэрээр олгоно:

27.2.1.гэр бүлийн шалтгаанаар;

27.2.2.цагаачлах;

27.2.3.хөдөлмөр эрхлэх;

27.2.4.хөрөнгө оруулах;

27.2.5.суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх болон хувийн бусад зорилгоор.

27.3.Дараахь тохиолдолд гадаадын иргэнд Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгохоос болон уг зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзах буюу хүчингүй болгож болно:

27.3.1.тагнуул, цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн;

27.3.2.энэ хуульд заасан виз, бүртгэл, оршин суух журмыг 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн;

27.3.3.энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа явуулсан;

27.3.4.виз, эрх бүхий байгууллагаас олгодог аливаа зөвшөөрөл, баримт бичгийг засварласан, хуурамчаар үйлдсэн, бүрдүүлсэн.

27.3.5.харьяалах улсын эрх бүхий байгууллагаас гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийг хүчингүй болгосон.

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

27.4.Монгол Улсын нутаг дэвсгэрт хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэдийн тоо нь Монгол Улсын харьяат хүн амын гурван хувь, үүний дотор нэг улсын иргэн нэг хувь хүртэл байж болно.

27.5.Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл авах хүсэлтээ гадаадын иргэн тус улсын хил нэвтэрсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

## **28 дугаар зүйл.Монгол Улсад гэр бүлийн шалтгаанаар оршин суух**

28.1.Монгол Улсын иргэнтэй гэр бүл болж гэрлэлтээ бүртгүүлсэн, түүнчлэн хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэний хамаарал бүхий этгээд нь тус улсад оршин суух хүсэлт гаргавал гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тэдгээрт Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг энэ хуулийн 27.1-д заасан хугацаагаар олгоно.

[/Энэ хэсэг т 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

[Энэ хэсэг т 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан/](#)

[/Энэ хэсэг т 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан/](#)

28.2.Энэ хуулийн 27.2.3-27.2.5-д заасан гадаадын иргэний Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн хугацаагаар түүний хамаарал бүхий этгээдийн тус улсад оршин суух зөвшөөрлийн хугацаа тодорхойлогдоно.

[/Энэ хэсэг т 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

28.3.Гэр бүлийн шалтгаанаар оршин суух гадаадын иргэн нь 55 буюу түүнээс дээш настай бол тухайн гадаадын иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчмыг баримтлан гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг хугацаагүйгээр олгож болно.

[/Энэ хэсэг т 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөл т оруулсан/](#)

28.4.Энэ хуулийн 27.3-т зааснаас гадна дараахь тохиолдолд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

гадаадын иргэнд Монгол Улсад гэр бүлийн шалтгаанаар оршин суух зөвшөөрөл олгохоос болон зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзах буюу хүчингүй болгоно:

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

28.4.1.энэ хуулийн 28.1-д заасан зөвшөөрлийг авах зорилгоор Монгол Улсын иргэнтэй хуурамчаар гэр бүл болсон;

28.4.2.Гэр бүлийн тухай хуулийн 11.2-т заасны дагуу гэрлэлт дуусгавар болсон.

## **29 дүгээр зүйл.Монгол Улсад цагаачлах**

29.1.Монгол Улсад цагаачлах эрх авах тухай гадаадын иргэний хүсэлт, улс орны дотоод нөхцөл байдал, эдийн засгийн чадамж, цагаачлах хүсэлтэй хүний боловсрол, мэргэжлийг харгалзан гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Монгол Улсад цагаачлан оршин суух зөвшөөрлийг энэ хуулийн 27.1-д заасан хугацаагаар олгоно.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

29.2.Монгол Улсад цагаачлах хүсэлт гаргасан гадаадын иргэн 55 буюу түүнээс дээш настай бол гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь цагаачлан оршин суух зөвшөөрөл олгохдоо энэ хуулийн 28.3-т заасан зарчмыг баримтална.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

29.3.Монгол Улсад цагаачлан оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэн жилд 180 хоногоос дээш хугацаагаар тус улсын нутаг дэвсгэрт байгаагүй бол гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь цагаачлах зөвшөөрлийг хүчингүй болгож болно.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

29.4.Монгол Улсад цагаачлан амьдрах оршин суух зөвшөөрөл авсан харьяалалгүй хүн гадаадад зорчих бол гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага түүнд гадаадад зорчих үнэмлэх олгоно.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

29.5.Монгол Улсад цагаачлан амьдрах оршин суух гадаадын иргэдийн тоо нь Монгол Улсын харьяат хүн амын 0.5 хувь, үүний дотор нэг улсын иргэн 0.17 хувь хүртэл байж болно.

29.6.Монгол Улсад цагаачлан амьдрах оршин суух гадаадын иргэдийн тоо нь Монгол Улсын харьяат хүн амын 0.4 хувиас доош байгаа нөхцөлд Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тус улсад цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоог харьяалах улс болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид оршин суух байршлаар нь бүрэн эрхийнхээ хугацаанд нэг удаа, 0.4 хувиас дээш гарсан нөхцөлд жил тутам тогтооно.

## **30 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулах, суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх зорилгоор Монгол Улсад оршин суух**

30.1.Хөрөнгө оруулах, хөдөлмөр эрхлэх, суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх зорилгоор Монгол Улсад ирсэн гадаадын иргэнд хөрөнгө оруулалт, хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тэдгээрийн эрх олгосон байгууллагын хүсэлтийг үндэслэн гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага оршин суух зөвшөөрөл олгоно.

[/Энэ хэсэгт 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

30.2.Гадаадын иргэн нь энэ хуулийн 30.1-д заасан зөвшөөрлийн хугацааг дуусахаас өмнө холбогдох байгууллагын хүсэлтийг авч гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хандаж оршин суух хугацааг сунгуулна.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

## **31 дүгээр зүйл.Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг хянан шийдвэрлэх хугацаа**

31.1.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг 60 хоногийн дотор, уг зөвшөөрлийн хугацааг сунгах хүсэлтийг 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

### 32 дугаар зүйл.Монгол Улсад албан хэргээр оршин суух

32.1.Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн болон гадаад улс, олон улсын хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэнд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус улсад оршин суух зөвшөөрөл олгож, хугацааг нь сунгана.

32.2.Төрийн байгууллагын урилгаар ирсэн болон Засгийн газар хоорондын байгууллагад ажиллах гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгох, хугацааг нь сунгах асуудлыг уригч байгууллагын хүсэлтийг үндэслэн гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

32.3.Энэ хуулийн 32.1-д заасан гадаадын иргэн оршин суух зөвшөөрөл авах хүсэлтээ тус улсын хил нэвтэрсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, энэ хуулийн 32.2-т заасан гадаадын иргэн оршин суух зөвшөөрөл авах хүсэлтээ тус улсын хил нэвтэрсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

### 33 дугаар зүйл.Гадаадын иргэнд үнэмлэх олгох

33.1.Монгол Улсад хувийн хэргээр болон энэ хуулийн 32.2-т заасны дагуу оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэнд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Монгол Улсад оршин суух үнэмлэх олгоно.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

33.2.Энэ хуулийн 33.1-д заасан оршин суух үнэмлэхэд дараахь мэдээллийг тусгана:

- 33.2.1.овог нэр;
- 33.2.2.төрсөн он, сар, өдөр;
- 33.2.3.хүйс;
- 33.2.4.оршин суух үнэмлэхийн дугаар;
- 33.2.5.түүний 16 насанд хүрээгүй хүүхэд;
- 33.2.6.иргэний харьяалал;
- 33.2.7.оршин суух зөвшөөрлийн төрөл;
- 33.2.8.оршин суух зөвшөөрлийн цуврал дугаар;
- 33.2.9.олгосон байгууллага;
- 33.2.10.хүчинтэй үргэлжлэх хугацаа;
- 33.2.11.сунгалт;
- 33.2.12.регистрийн дугаар;
- 33.2.13.зөрчлийн тэмдэглэл;
- 33.2.14.байнга оршин суух хаяг, түүний өөрчлөлт;
- 33.2.15.гарын хурууны хээ.

33.3.Гадаадын иргэн Монгол Улсаас бүр мөсөн явах тохиолдолд оршин суух үнэмлэхээ гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хураалгана.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

## ДОЛДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСААС ГАРАХ

### 34 дүгээр зүйл.Монгол Улсаас гарах, гарахыг түдгэлзүүлэх

34.1.Гадаадын иргэн Монгол Улсад байхыг зөвшөөрсөн хугацаанд багтаж тус улсаас гарна.

34.2.Дараахь үндэслэл байвал гадаадын иргэнийг дор дурдсан хугацаанд Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлнэ:

34.2.1.гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан бол эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл;

34.2.2.шүүхээр ял шийтгүүлсэн бол ялаа эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөх, эсхүл тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын

олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэх хүртэл;

34.2.3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу тухайн гадаадын иргэнийг Монгол Улсаас гарах, гарахыг түр түдгэлзүүлэх тухай шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол.

*/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

34.2.4.шүүхээс иргэний хэрэг үүсгэж, тухайн гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түр түдгэлзүүлэх тухай шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамж гарсан бол.

*[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)*

34.3.Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түр түдгэлзүүлэх тухай шийдвэрийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга холбогдох байгууллагын саналыг үндэслэн гаргана.

*[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)*

34.4.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 34.3-т заасан шийдвэрийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

*[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)*

### **35 дугаар зүйл.Монгол Улсаас гарахыг сануулах**

35.1.Энэ хуулийн 27.3-т заасан үндэслэлээр оршин суух зөвшөөрөл олгоогүй, эсхүл урьд олгосон зөвшөөрлийг хүчингүй болгосон буюу зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзсан бол Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус улсаас сайн дураараа гарахыг гадаадын иргэнд сануулна.

*[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)*

35.2.Энэ хуулийн 35.1-д заасан сануулга авсан гадаадын иргэн 10 хоногийн дотор Монгол Улсаас гарах үүрэгтэй.

### **36 дугаар зүйл.Гадаадын иргэнийг саатуулах**

36.1.Дор дурдсан үндэслэл байвал гадаадын иргэнийг саатуулж болно:

36.1.1.энэ хуулийн 35.2-т заасан хугацаанд гараагүй бол;

36.1.2.албадан гаргах ажиллагаанд саад учруулж, эсхүл гэмт хэрэг үйлдэж, зөрчил гаргаж болзошгүй бол;

36.1.3.паспорт буюу паспортыг орлох баримт бичиггүй, эсхүл хэн болох нь тогтоогдохгүй байгаа бол.

36.2.Энэ хуулийн 36.1.3-т заасан зөрчил гаргасан гадаадын иргэнийг мөн хуулийн 41.1-д заасан гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн шийдвэрээр зургаан цагаас илүүгүй хугацаагаар түр саатуулж болно.

*[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)*

36.3.Энэ хуулийн 36.1-д заасан үндэслэлээр гадаадын иргэнийг шүүхийн шийдвэрээр 14 хүртэл хоногийн хугацаагаар саатуулж болох ба шаардлагатай тохиолдолд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн уг хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болно.

*[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)*

36.4.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гадаадын иргэнийг саатуулахад гарсан зардлыг өөрөөр нь, эсхүл энэ хуулийн 10.1.2–т заасан баталгаа гаргасан иргэн, аж ахуй нэгж, байгууллагаар төлүүлж болно.

*[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)*

36.5.Энэ хуулийн 36.1.1, 36.1.3-т заасан зөрчил гаргасан гадаадын иргэнийг тодорхой барьцаатайгаар саатуулахгүй байж болно.

36.6.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь саатуулсан гадаадын иргэний талаар гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

*[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)*

36.7.Нийслэлд болон хилийн боомтод гадаадын иргэнийг саатуулах байртай байх бөгөөд уг байрны дотоод журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## 37 дугаар зүйл. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх

[/Энэ зүйлийн гарчиг т 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

37.1. Гадаадын иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал дараахь үндэслэлээр Монгол Улсаас албадан гаргана:

37.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр бус буюу хуурамч баримт бичгээр нэвтэрсэн нь нотлогдсон;

37.1.2. Оршин суух зөвшөөрлийн хугацаа нь дууссан боловч Монгол Улсаас гарч явахаас зайлсхийсэн;

37.1.3. Түр ирэгч нь виз, бүртгэлийн журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж хуульд заасан хариуцлага хүлээсэн;

[/Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

37.1.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан;

37.1.5. Сэтгэцийн өвчтэй болохыг нь эрүүл мэндийн байгууллага тогтоосон;

[/Энэ заалтад 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

37.1.6. Хуурамч баримт бичиг ашиглаж виз, оршин суух зөвшөөрөл авсан, эсхүл виз, оршин суух зөвшөөрлийг засварласан буюу хуурамчаар үйлдсэн;

37.1.7. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхэлсэн, ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан;

37.1.8. Энэ хуулийн 35.1-д заасны дагуу Монгол Улсаас сайн дураараа гарах сануулгыг биелүүлээгүй;

37.1.9. Нийгмийн хэв журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж хуульд заасны дагуу хариуцлага хүлээсэн гадаадын иргэний талаар цагдаагийн байгууллагаас үндэслэл бүхий санал ирүүлсэн;

[/Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

37.1.10. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын эсрэг үйл ажиллагаа явуулж болзошгүй этгээд гэж холбогдох байгууллагаас үзсэн;

37.1.11. Шүүхээр ял шийтгүүлсэн гадаадын иргэн ялаа эдэлж дууссан буюу ялаас чөлөөлөгдсөн, эсхүл тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэхээр болсон;

37.1.12. Түр ирэгч визийн хугацааг хэтрүүлсэн.

37.2. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах тухай шийдвэрийг гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга гаргана. Гадаадын иргэн нь албадан гаргасан үндэслэлээс хамааран 1-10 жилийн хугацаанд Монгол Улсад орох эрхгүй байна.

[/Энэ хэсэгт 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

37.3. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсаас албадан гаргаж байгаа гадаадын иргэний фото зураг, гарын хурууны хээг авч мэдээллийн сан бүрдүүлнэ.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

37.4. Энэ хуулийн 37.2-т заасан албадан гаргах тухай шийдвэрийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хил хамгаалах болон цагдаагийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

37.5. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь албадан гаргаж байгаа гадаадын иргэний тухай мэдээлэл, Монгол Улсад орохыг хориглосон хугацааг гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн санд оруулна.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

37.6. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах зардлыг гадаадын иргэнээс өөрөөс нь, эсхүл уригчаас гаргуулах ба хэрэв төлбөрийн чадваргүй бол уг зардлыг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргана.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус](#)

[өөрчлөл т оруулсан/](#)

37.7.Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах нь улс хооронд ялтан шилжүүлэх асуудалд үл хамаарна.

37.8.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь албадан гаргасан гадаадын иргэний талаар гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр мэдээлнэ.

[/Энэ хэсэг т 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар т ус т ус өөрчлөл т оруулсан/](#)

37.9.Энэ хуулийн 37.1.2, 37.1.12-т заасан зөрчил гаргасан гадаадын иргэн хувийн нөхцөл байдал, ар гэрийн гачигдал, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон, эсхүл эрүүл мэндийн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хүсэлт гаргасан, эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 43.3 дугаар зүйлийн 1.6-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн албадан гаргахаас чөлөөлөх эсэхийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

37.10.Албадан гаргасан гадаадын иргэний Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга сунгаж болно. Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг сунгахтай холбоотой асуудлыг энэ хуулийн 9.2.3-т заасан журмаар зохицуулна.

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

### **38 дугаар зүйл.Гадаадын иргэнийг шилжүүлэх улс**

38.1.Албадан гаргаж байгаа гадаадын иргэнийг харьяалах улсад нь шилжүүлнэ.

38.2.Албадан гаргаж байгаа гадаадын иргэнийг харьяалах улсад нь шууд шилжүүлэх боломжгүй бол дараахь улсын аль нэгэнд шилжүүлж болно:

38.2.1.урьд нь оршин сууж байсан буюу төрсөн улсад нь;

38.2.2.Монгол Улсад нэвтрэн орж ирэхдээ хамгийн сүүлд дамжин орж ирсэн улсад нь;

38.2.3.визийг нь авсан улсад.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ ГАДААДЫН ИРГЭНИЙ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЖИЛТНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, БАТАЛГАА**

[/Энэ хэсэг т 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар т ус т ус өөрчлөл т оруулсан/](#)

### **39 дүгээр зүйл.Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо**

39.1.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь удирдах төв байгууллага, түүний хилийн боомт, орон нутаг дахь албадаас бүрдэнэ.

[/Энэ хэсэг т 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар т ус т ус өөрчлөл т оруулсан/](#)

39.2.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын алба ажиллах хилийн боомтын жагсаалтыг Засгийн газар тогтооно.

[/Энэ хэсгийг 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон/](#)

39.3.Энэ хуулийн 39.2-т зааснаас бусад хилийн боомтод гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын виз олгохоос бусад чиг үүргийг тухайн боомт дахь хил хамгаалах байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

[/Энэ хэсгийг 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон/](#)

### **40 дүгээр зүйл.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх**

[/Энэ зүйлийн гарчиг т 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар т ус т ус өөрчлөл т оруулсан/](#)

40.1.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

[/Энэ хэсэг т 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар т ус т ус өөрчлөл т оруулсан/](#)

[тус өөрчлөлт оруулсан/](#)

40.1.1.гадаадын иргэний талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

40.1.2.гадаадын иргэний талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

40.1.3.гадаадын иргэний асуудлаар Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

[/Энэ заалт ад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

40.1.4.гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн цаасан болон цахим мэдээллээс бүрдсэн нэгдсэн санг хөтлөх, сангийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг хангах, сангаар дамжуулан төрийн холбогдох байгууллагатай харилцан мэдээлэл солилцох;

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

40.1.5.олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

40.1.6.Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх шийдвэр гаргах;

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

40.1.7.Монгол Улсад цагаачлан оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэний гарах-орох мэдэгдлийг бүртгэх. Энэ мэдэгдлийг гадаадын иргэн Монгол Улсын хилээр гарах орохоосоо 72 цагаас доошгүй хугацааны өмнө гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

40.1.8.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

[/Энэ заалтын дугаарт 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

40.2.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 27.3-т заасны дагуу татгалзсан хариу өгсөн тохиолдолд шалтгааныг нь тайлбарлах үүрэг хүлээхгүй.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

#### **40<sup>1</sup> дүгээр зүйл.Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан**

[/Энэ зүйлийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

40<sup>1</sup>.1.Монгол Улс нь гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай байна. Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь төрийн өмч байх бөгөөд улсын хилээр нэвтрэх зорчигчийн бүртгэлийн нэгдсэн сантай холбогдоно.

40<sup>1</sup>.2.Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь Монгол Улсын виз мэдүүлсэн, виз олгосон, виз олгохоос татгалзсан, Монгол Улсын хилээр нэвтэрсэн, Монгол Улсад түр ирэгч, албан хэргээр болон хувийн хэргээр оршин суусан, Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн, албадан гаргасан, албадан гаргахаас чөлөөлөгдсөн, Монгол Улсад тааламжгүй этгээдээр зарлагдсан зэрэг гадаадын иргэний талаарх цаасан болон цахим мэдээллийн сангаас бүрдэнэ.

40<sup>1</sup>.3.Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн нууцлалыг хангах үүргийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээнэ.

40<sup>1</sup>.4.Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг цахим хэлбэрээр бүрдүүлэх, хөгжүүлэх болон төрийн мэдээллийн бусад сантай мэдээлэл солилцох, эрх бүхий байгууллага хамтран ашиглах боломжтой байна.

40<sup>1</sup>.5.Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ашиглах, мэдээлэл нийлүүлэх, солилцох журмыг хууль зүйн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

#### **41 дүгээр зүйл.Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, түүний бүрэн эрх, баталгаа**

[/Энэ зүйлийн гарчигт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

41.1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх эрх олгогдсон Монгол Улсын иргэнийг гадаадын иргэний хяналтын улсын байцаагч гэнэ.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

41.2.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний хяналтын улсын ерөнхий байцаагч байна.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

41.3.Гадаадын иргэний хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч (цаашид "байцаагч" гэх)-ийн эрх олгох, уг эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг гадаадын иргэний хяналтын улсын ерөнхий байцаагч шийдвэрлэнэ.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

41.4.Улсын байцаагч нь "Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч би, Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангахын төлөө үнэнчээр зүтгэж, гадаадын иргэн болон түүний баримт бичигт хяналт, шалгалт хийхдээ хүний эрх, хууль, шударга ёсыг дээдлэн, улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, хэний ч нөлөөнд үл автахаа батлан тангараглая. Өргөсөн тангаргаас няцвал төрийн хуулийн цээрлэл хүлээнэ" гэсэн тангараг өргөнө.

[/Энэ хэсэгт 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/](#)

41.5.Улсын байцаагч нь дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх ба дүрэмт хувцас, ялгах тэмдгийн загвар, хэрэглэх журам, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

41.6.Улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэгтэй ижил загварын дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэхийг бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хориглоно.

41.7.Улсын байцаагч Төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

[/Энэ хэсэгт 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

41.7.1.улсын хилээр нэвтрэх эрхийн баримт бичигт үзлэг шалгалт хийж, зөрчлийг арилгуулах;

[/Энэ заалтыг 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон/](#)

41.7.2.гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичигт үзлэг шалгалт хийж, зөрчлийг шийдвэрлэх хүртэл хадгалах, эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

[/Энэ заалт ад 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

41.7.3.гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах албадан гаргахаас чөлөөлөх тухай дүгнэлт гаргах;

[/Энэ заалт ад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

41.7.4.гадаадын иргэнийг Монгол Улсаас гаргахыг түдгэлзүүлсэн, албадан гаргасан шийдвэрийг цуцлах санал гаргах;

41.7.5.албан үүргээ гүйцэтгэх үед улсын хил нэвтрэх;

[/Энэ заалтыг 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон/](#)

41.7.6.хууль тогтоомжид заасан бусад.

[/Энэ хэсгийг 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

41.8.Улсын байцаагчийн хилийн боомтод ажилласан нэг жилийг нэг жил гурав сар ажилласанд тооцох ба хилийн боомт, орон нутаг дахь албанд таваас доошгүй жил ажиллаж байгаа ажилтанд ажилласан таван жил тутам 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгоно.

41.9.Улсын байцаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ дараах тусгай хэрэгсэл, мэх ашиглаж болно:

41.9.1.нэг бүрийн тусгай хэрэгсэл;

41.9.2.тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл;

41.9.3.хамгаалах тусгай хэрэгсэл;

41.9.4.бие хамгаалах урлагийн зэвсэггүйгээр тулалдах мэх.

[/Энэ хэсгийг 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

41.10.Энэ хуулийн 41.9-д заасан тусгай хэрэгсэл, мэхийг дараах тохиолдолд ашиглаж болно:



41.10.1.улсын байцаагчийн хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлээгүй, эсхүл хүч хэрэглэж эсэргүүцсэн;

41.10.2.хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон.

[/Энэ хэсгийг 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

41.11.Тусгай хэрэгсэл, мэх хэрэглэснээс хүний амь бие, эрүүл мэндэд гэмтэл учирсан тохиолдолд улсын байцаагч эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ авч, энэ тухай харьяа байгууллагын даргад мэдэгдэнэ.

[/Энэ хэсгийг 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

41.12.Тусгай хэрэгслийн жагсаалт, хэрэглэх, хадгалах зааврыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн батална.

[/Энэ хэсгийг 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

## **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ**

### **ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА**

#### **42 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

42.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

42.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

[/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

## **АРАВДУГААР БҮЛЭГ**

### **БУСАД АСУУДАЛ**

#### **43 дугаар зүйл.Хугацаа тодорхойлох, тоолох журам**

43.1.Виз, оршин суух зөвшөөрлийн хугацааг жил, сар, хоногоор тодорхойлно.

43.2.Виз, оршин суух зөвшөөрлийн хугацааг тоолохдоо дараагийн өдрөөс эхлэн тоолно.

43.3.Энэ хуулийн 43.2-т заасан тоолох хугацааны эцсийн өдөр ажлын бус өдөр байвал түүний дараагийн ажлын өдөр уг хугацаа дуусна.

43.4.Виз, оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгах тохиолдолд хугацаа дууссан өдрөөс шинэ хугацааг тоолно.

#### **44 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

44.1.Энэ хуулийг 2010 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ